

# ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТОД АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

*Зорилго:*

Газрын 2014 оны гүйцэтгэлд дүгнэлт хийж, гарсан ололт, үр дүнг бататган, салбарын хууль тогтоомж, хөгжлийн шинэ бодлого, зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг оновчтой тодорхойлох зэрэг удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлж, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

## **1. Төлөвлөгөөт хяналт шалгалт**

### **1.1 Ноосны урамшуулал олголтын нэгдсэн сангийн гүйцэтгэл:**

2013 онд нийт 4 сумын 570 малчин өрхөд ноосны урамшуулалд 236,2 сая төгрөг олгохоор тайланг сумдын МЭҮТ-уудаар дамжуулан материалаа хүлээн авсан байна. Хонь, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журмын 3.5-д заасаны дагуу Сумын МЭҮТасгийн ажилтан нь жил бүрийн 8 дугаар сарын 31-ны дотор дээд байгууллагадаа материалыг өгнө гэж заасныг зарим сумдын МЭҮТасгууд тодорхой шалтгааны улмаас хугацаа хоцроож өгсөн байна. Үүнд 2013 онд 80 гаруй малчны хүний овог, нэр буруу бичих, регистрийн дугаарыг алдаатай бичих зэрэг алдаа гаргаж байсныг газрын мэргэжилтэн нь тулгалт хийж байхдаа залруулж байсан сайн талтай байна.

Программын хувьд бодолтыг автоматаар хийгдэхээр тохируулаг хийгдсэн байна. Жил ирэх тутам ноосны урамшуулалд хамрагдах иргэдийн материал нэмэгдэх хандлагатай байна.

*Цаашид анхаарах нь:* Энэ үйл ажиллагаа нь 2011 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд малчдын А дансыг үндэслэн тухай малчин олгох урамшууллын дээд хэмжээ тогтоогдог тул мал тооллогыг чанартай хийх, нэг бүрчлэн тоолох, хяналтын тоог сайтар хийх зэрэг хэрэгцээ шаардлага гарч байна. Нөгөөтэйгүүр зөвхөн хоршооны гишүүн малчинд энэ урамшуулал олгогдохоор болж байгаа тул малчдын хоршооны ойлголтыг нэмэгдүүлэх, ач холбогдолыг сурталчлах сургалт, уулзалт, зөвлөгөөнийг нэмэгдүүлэх, гарын авлага мэдээллээр хангах зэрэг ажлуудыг эрчимжүүлэх. Цаашлаад улсын хэмжээнд малчдын хоршоодод шалгуур үзүүлэлт тогтоон зөвхөн шалгуур үзүүлэлтийг хангасан хоршооны гишүүн малчинд урамшуулал олгодог болох, мөн мал ээмэгжүүлэлттэй холбож өгөх шаардлага байна. Ингэснээр малчид зөвхөн урамшуулалд хамрагдахын тулд хоршоо байгуулдаг биш хоршооны жинхэнэ мөн чанарыг танин мэдэх, хоршоодын нийгэм үзүүлэх үр нөлөө ч нэмэгдэх юм.

## **1.2 “Чацаргана” хөтөлбөрийн хэрэгжилт:**

“Чацаргана” үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 04-р сарын 14-ний өдрийн 23 дугаар тогтоолоор батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Хөтөлбөрийн хүрээнд 5 жилийн хугацаанд 12 аж ахуйн нэгж, 13 иргэнд 49,8 га талбайд тариалах 139.2 сая төгрөгийн өртөг бүхий 62325 ширхэг чацарганы суулгацыг 5 жилийн хугацаатай зээлээр олгосон байна.

Хувийн хэргийн бүрдэлт сайн бөгөөд хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнээс хойш хамаарах материалууд бүгд бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, тайлан, судалгааны материалуудаар баяжилт хийсэн, суулгац зээлээр авч зөөж, тээвэрлэх, хадгалаж, тариалах журамтай байгаа нь үр дүнтэй байна.

ҮХААЯамнаас хөтөлбөртэй холбогдуулж хавар, намар улиралд жилд 2 удаа төсөл шалгаруулж ирүүлэх тухай албан бичиг ирсэний дагуу холбогдох хугацаануудад нь шат дараатай арга хэмжээнүүдийг авч бүх сумдад албан тоотоор мэдээлэл хүргүүлсэн байна. Хаврын төсөл шалгаруулалтын үеэр 1 иргэн, 1 ААНБ хамрагдаж нийт 10000 ширхэг суулгац зээлийн гэрээ байгуулж авч нийт 8 га талбайд тариалалт хийсэн байна. Харин намрын сонгон шалгаруулалтыг Сумдын ЗДТГ, орон нутгийн ТВ-нүүдээр зарлуулсан боловч нэгч иргэн, аж ахуйн нэгжээс хүсэлт ирүүлээгүй байна. Төсөл хөтөлбөрийн бүрдүүлэлтийн хувьд жимс, жимсгэний газрын гэрчилгээг нь авдаг учир талбай давхардахгүй, талбайгаа хашаажуулсан байдал, туршлага зэргийг харгалзан олгож байгаа сайн талтай байна.

*Цаашид анхаарах нь:* Уг төслийн зээл нь урт хугацаатай учир эргэн төлөлтөн дээр анхаарах, барьцаанд тавьсан хөрөнгөнд хяналт тавих, зээлийн хувийн хэргийг сайтар хадгалах хэрэгтэй. Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнээс хойш 49.8 га-д тариалалт хийгдсэн бөгөөд 2014 онд 41.21 тн жимс хураан авсан үзүүлэлттэй байгаа боловч хадгалах агуулах, жимс, жимсгэн боловсруулах үйлдвэр байхгүй, орон нутгийн зүгээс жимс жимсгэнэ тариалах газар олдохгүй байгаа шалтгааны улмаас жил ирэх тутам чацаргана тариалах иргэдийн тоо болон хэмжээ буурч байгааг анхаарч зохих бодлогын арга хэмжээг авах нь зүйтэй байна. Сумдын ЗДТГ-тай хамтран иргэд, аж ахуй нэгжүүдээр зээлийг эргэн төлөх хуваарийн дагуу хийлгэж ажиллах тал дээр анхаарч ажиллах.

## **1.3 Агропаркийн ашиглалт, лизингээр олгосон бага оврын тракторийн нөхцөл, байдал:**

2007 онд анх хэрэгжиж эхэлсэн төсөл бөгөөд Дархан сумын Агропаркад гэрээ байгуулсан 13 иргэн, 1 бүлэг нийт 11,1 га талбайд хүрэн манжин, шар

манжин, сонгино, төмс, лууван, өргөст хэмх, амтат гуа, хулуу зэрэг таримлуудыг тариалсан байна. Дархан сумын агропаркын хувьд тариалангийн газраа хашаалуулж хамгаалсан бөгөөд төвөөс зайдуу байршилтай тул иргэд өдөр бүр тариалсан ногоогоо арчлахад унааны зардал өндөр тусдаг байна. Мөн борлуулалтын нэгдсэн сүлжээгүй байгаа нь тариаланчдын гарт очих тэр хэмжээгээр бага тусаж байгаа нь ашиглалт хангалтгүй байх нэг шалтгаан болж байна. 2014 онд агропаркуудыг тулгуурлан ҮХААЯ, ХААШУОНТөв, сумдын МЭҮТасгуудтай хамтран 3 удаагийн сургалтыг зохион байгуулж 97 хүнийг хамруулснаар төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдэд техник үр шинэчлэл болон технологийн мэдлэгийг дээшлүүлсэн байна. Бусад сумдад байгуулагдсан Агропаркуудын ашиглалт хангалтгүй байна. Цаашид сумдын МЭҮТ-ын хариуцсан мэргэжилтэний үр дүнгийн гэрээнд тусгуулан ажиллуулахаар шийдвэрлэх зүйтэй байна. Агропаркууд сумын ЗДТГ-ийн мэдэлд шилжүүлж хөрөнгөнд тусгуулсан байна.

2012, 2013, 2014 онд олгосон бага оврын тракторын судалгааг сумдад албан тоотоор хүргүүлэн гэрээнд заагдсаны дагуу эргэн төлөлтөн дээр хяналт тавин ажилласан байна. Нийт тус аймгийн 4 сумдад газар тариалангийн зориулалттай 38, хадлангийн зориулалттай 162 тракторийг олгосон байна. Үүний гол материалууд нь буюу зээлийн гэрээ, барьцаа, бусад бичиг баримт нь ХААН банк, ТЭДСан дээр төвлөрдөг юм байна. Мөн манай газраас эдгээр иргэдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгохыг дэмжсэн албан тодорхойлолтууд гаргаж өгсөн байна.

Манай газраар дамжиж зээл олголт хийгддэггүй ч эдгээр техник хэрэгсэл нь сум орон өвөлжилтийн бэлтгэл ажил хангах, хүнсний ногооны хаврын тариалалтын ажилд чухал үүрэг гүйцэтгэдэг техник хэрэгсэл тул сумын болон багийн засаг даргын хүсэлтийг уламжилж ТЭДС-д дэмжиж буй хүсэлтэй явуулдаг байна. Мөн ТЭДСангаас эдгээр бага оврийн трактор авсан иргэдэд дагалдах агрегатуудыг нийлүүлж байгаа тул иргэдийг мэдээллээр хангаж, хамрагдалтыг нэмэгдүүлж малчид, тариаланчдын механикжуулалтыг сайжруулах боломж байна.

#### ***1.4 Улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтын хүрээнд олгосон эм, вакцин, хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хамгаалалт, ажил үйлчилгээний чанар:***

2014 онд 4 сумын МЭҮТасгийн мэргэжилтэнүүд, МЭҮН-үүдтэй гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд 10 нэр төрлийн халдварт өвчнөөс сэргийлэх тарилганд давхардсан тоогоор 370,4 мянган толгой малыг хамруулж, 350 л шингэн, 8,0 мянган тун хуурай вакцин зарцуулсан байна. Энэ арга хэмжээний үр дүнд боом, галзуу, мялзан, цусан халдварт зэрэг мал амьтаны халдварт өвчин гараагүй тайван байна. Бруцеллёзоос сэргийлэх тарилгыг зөвхөн шинээр гарсан 19,0 мянган тугал, 122,0 мянган хурга, ишгэнд хийхээр МЭҮН-үүдэд

141,0 мянган тун тарилгыг хуваарилан олгосноор 18645 тугал, 81206 хурга, 40161 ишгийг хамруулсан байна. Бруцеллёзын тарилгыг тогтмол хийснээр уг өвчний халдварлалт аймгийн хэмжээнд 0,3 хувь хүртэл буурсан дүнтэй байна.

Мал бүхий 1395 өрхийн 1589 өвөлжөө хашааны 271,5 мянган метр кв талбайд төлөвлөгөөт болон урдьчилан сэргийлэх ариутгалыг хийж хувийн мал эмнэлгийн нэгжүүд өөрийн хөрөнгөөр повидон иод 1350 л, хлорын шохой 1300 кг, Хай коф 150 кг –ыг тус тус худалдан авч зарцуулсан байна. Эдгээр арга хэмжээний үр дүнд шинээр халдварт өвчний голомт гараагүй байна.

Вакцинжуулалт, тарилгад хамруулсан байдлыг түүврийн аргаар Орхон, Хонгор, Дархан сумын 15 малчдын гэрээр очиж танилцахад ямар нэг зөрчил илрээгүй.

Аймгийн хэмжээнд Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ явуулахад баримтлах жишиг үнэлгээг АИТХТэргүүлэгчдийн 2013.03.15-ны өдрийн 20 дугаар тогтоолын дагуу бүх сумын МЭҮНэгжүүд мөрдлөгө болгон ашигладаг байна.

Тухайн МЭҮН-ийн вакцинжуулалт хийсэн гүйцэтгэлд сумын Байцаагч нь шалгалт хийж, дүгнэлт гаргадаг бөгөөд түүнийг үндэслэн сумын засаг дарга нар үйлчилгээний хөлс олголтын тодорхойлолт ирүүлснийг тус газрын МЭХ-ийн Дарга тулгалт хийн, хянадаг бөгөөд санхүү дээр очдог байна.

МЭҮН-ийн ажилтан нь ямарваа нэгэн халдваргүйжүүлэлтийн ажил гүйцэтгэсэн мэдээгээ санаатайгаар засварласан, өсгөсөн тохиолдол илэрвэл үйл ажиллагааны санхүүжилтийг зогсоох арга хэмжээ авч байх, тарилга хийсэн цуваан дээрээ малчины тамга тэмдэг дардасыг даруулж байх /ингэснээр баталгаа болно/, вакциныг горим технологийн дагуу хугацаанд нь хорогдолгүй ашиглаж байх, сумын МЭҮТ, МХГ байцаагч нар вакцинжуулалтанд хамруулсан байдлыг шалгахдаа тухайн гүйцэтгэлийн 30 орчим хувьд тандалт хийж байвал үр дүнтэй юм.

Тайлан гаргасан

Захиргаа удирдлагын хэлтсийн дарга бөгөөд дотоод аудит,ХШҮ, тайлан мэдээ, программ хангамж, дотоод сүлжээ, хэвлэл мэдээлэлхариуцсан мэргэжилтэн

Б.Бат-Эрдэнэ